



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 8

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг 2018 оны 05 дугаар сарын сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минутад аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ч.Эрдэнэбаатар, Г.Болд, Г.Лхагвахатан Б.Сүнгээ, Л.Бат-Октябрь, Б.Баярсайхан, С.Бат-Эрдэнэ, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Хэлэлцэх асуудал:

1. Төрийн албаны зөвлөлийн албан бичиг танилцуулах
2. Төрийн захиргааны болон Төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалтын комисс томилох
3. ТАМШ-ын комисс томилох

СОНССОН НЬ 1.

Ж.Ганбаатар: Төрийн албаны салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааг дүгнэсэн албан бичгийг гишүүдэд танилцуулав.

ШИЙДВЭЛЭСЭН НЬ:

Гишүүд 2018 оны үйл ажиллагаан дээрээ сайн анхаарч төлөвлөгөөнд орсон ажил үйлчилгээгээ сайн биелүүлэхийг анхаарууллаа.

СОНССОН НЬ 2:

Ж.Ганбаатар: Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдөр бүртгээд 07-ны өдөр явагдах байгаа. Шалгалтын сонгон шалгаруулах комиссыг томилно.

Төрийн захиргааны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын комиссын даргаар С.Бат-Эрдэнэ, нарийн бичгийн даргаар Ч.Болормаа, гишүүдэд Г.Болд нар, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын комиссын даргаар С.Бат-Эрдэнэ, нарийн бичгийн даргаар Ч.Болормаа, гишүүдэд Г.Болд, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Ц.Мөнгөнзул, Боловсрол соёл урлагийн

газрын мэргэжилтэн Н.Баатарцогт нарыг томилж байна. Шалгалтыг журмын дагуу авч хурал танилцуулах

ШИЙДВЭЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Төрийн захиргааны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилохоор шийдвэрлэв.

СОНССОН НЬ 3:

Ч.Болормаа: Төрийн албаны мэргэшлийн шалгалт 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр явагдана.

Ж.Ганбаатар: Салбар комиссын даргаар Г.Лхагвахатан, нарийн бичгийн даргаар Ч.Болормаа, Гишүүдэд Ч.Эрдэнэбаатар, Л.Бат-Октябрь, Г.Болд нарыг оруулахыг санал болгож байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилохоор шийдвэрлэв.

Хурал: 11:30 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН:

Ч.БОЛОРМАА

